


‘ЭРТНИЙ ХОЁР МӨРӨН, ЕГИПЕТ УЛС НЭМЭЛТ УНШИХ МАТЕРИАЛ

Байгаль газарзүй



Хоёр мөрний сав газар нь **Тигр, Евфрат** мөрний хооронд орших өргөн уудам, үржил шимт нутаг юм. Тус нутаг нь Энэтхэг, Газар дундын тэнгис, Ази, Европ тивийн зааг болдог.

Нил мөрөн



Хүмүүсийн ахуй амьдрал, нийгэм

Монголчууд эртнээс Египетийг Мисир орон гэж нэрлэдэг байв. Эртний мисирүүдийн амьдрал Нил мөрнөөс бүхэлдээ хамаардаг байв. Нил мөрний урт 6700 орчим км, дэлхийн хамгийн урт мөрөн. Энэ нь эртний Египетийн соёл иргэншлийг хөгжүүлэх үйлсэд үржил шимийг бий болгосноор түүний хөндийн оршин суугчдын амьдралын чухал эх үүсвэр гэсэн үг юм. Энэ нь Африк тивийн эдийн засаг, соёл, аялал жуулчлал, өдөр тутмын амьдралд нөлөөлсөн.

Эртний хоёр мөрний улсууд	Эртний Египет
- Хоёр мөрний улсууд услалтын систем, хуурай цаг улиралд ашиглах усан сан, далан байгуулж, арвай буудай их хэмжээгээр тарьдаг байжээ. - Шүмэрүүд зэс, хүрэл боловсруулахыг мэддэг, хүн төрөлхтний түүхэнд анх удаа бичиг үсэг, анжис, далбаат завь, модон дугуйтай тэрэг, тоосго зохион бүтээсэн. - Дээд давхрагын зарим эмэгтэйчүүд бичиг үсэгтэй байсан мэдээ бий.	- Эртний Египетүүд Нил мөрний дагуу суурин, хот байгуулж, газар тариалан, мал аж ахуй, ялангуяа загасны аж ахуй эрхлэн амьдардаг байв. - Тэд хөдөлмөрийг 10 өдрөөр хуваарилдаг, 2 нь амралтын, 8 нь ажлын өдөр байсан. - Баян ядуу хэн боловч, нимгэн даавуу бүсэлхийдээ зангидан уяж, маалинган нөмрөг нөмөрч, улавч өмсдөг байв.

Хоёр мөрний улсын нийгмийн давхарга

ЭРТНИЙ ЕГИПЕТИЙН НИЙГМИЙН ДАВХРАА



Соёл урлаг

Эртний хоёр мөрний улсууд	Эртний Египет
- Шүмэрүүд шаантаг бичиг зохион хэрэглэж байв. - 12 сартай он тооллыг анх зохиов. - 100м хүртэл өндөр зиггурат байгуулж, хотын төвдөө байрлуулж байв. - Хамгийн анхны бичмэл хуулийг бүтээсэн. (Хаммурапи хааны хууль) -	- Бичиг үсэг мэддэг хүн засгийн хамгийн өндөр албан томилогддог. - Египетийн бичиг үсгийг йероглиф гэнэ. - Египетийн тахилын байгууламжийг пирамид гэж нэрлэдэг. - Пирамидын дотор фараоныг занданшуулан, муми болгож оршуулдаг байсан.

Түлхүүр ухагдахуун

Папирус	Египет, Арабаас гаралтай, 5м өндөр намагт ургадаг ургамал. Энэ ургамалаар Египетүүд дээс, гутал, загасны тор, цаас хийдэг байв.
Пирамид	Эртний Египетийн шашинд хойд насны амьдралын тухай үзэл санаа шийдвэрлэх үүрэгтэй байсан нь пирамид, бунхан, нийт уран уран барилгын хэв загварт нь тусгалаа олжээ. Хүн үхсэний дараа амьдрал нь үргэлжлэн мөнхийн хутгийг олно, хойд насны амьдралдаа нухацтай бэлтгэх нь хүний энэ хорвоо дээрх амьдралын гол утга гэж сургадаг байсан тул ирээдүйн бунхнаа зохих ёсоор тохижуулахад онцгой анхаардаг байжээ.
Муми	

Зиггурат	Шумерийн тахилын байгууламж
Хаммурапи хууль	НТӨ 1792-1750 оны үед амьдарч байсан эртний Вавилон улсын I хаанчлалын 6 дугаар хаан Хаммурапийн хуулийг Францын археологийн экспедиц 1901 онд Сузы хотоос олжээ. Тэр нь одоогоор Парисийн Луврийн музейд хадгалагдаж байгаа. Хууль тогтоомжийг хар хүрэн чулуун багана дээр сийлж бичсэнийг дайны олз болгон Вавилоноос эламчууд нутагтаа аваачсан ажээ. Хуулийн эмхтгэл нь 282 зүйлтэй боловч чулуун баганад дээр одоо 247 нь бүтэн үлдэж, 35 зүйлийг нь Эламын хааны зарлигаар хусаж арилгасан бололтой

Зурган эх сурвалж: (1-Пирамид, 2-Муми, 3-Хаммурапи хааны хууль,)

